



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠳᠤ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГИЙН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/155

Алтай хот

**Дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлтийн 38.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 78 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн 3.2.7, 3.4.3 дахь зорилтын хүрээнд Англи Улсын Лондон хотод болох англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцох Бөхбатын Хулганаад дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан эх үүсвэрээс гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хяналт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР